

MRSA

Метициллинд тэсвэртэй *алтлаг Стафилококк (MRSA)* – өвчтөнд өгөх мэдээлэл

Халдвар хамгааллын эмч нарын халдвар хамгааллын хуудас

MRSA гэж юу вэ?

MRSA нь Метициллинд тэсвэртэй *алтан өнгийн Стафилококк* бактери буюу нян юм. MRSA стафилококк нь зарим антибиотикд эсэргүүцэлтэй (тэсвэртэй). Бусдаар бол антибиотикд мэдрэг энгийн стафилококкоос ялгаагүй. *Алтлаг Стафилококк* нь арьс ба салслагт байрлаж, ихэнхдээ зовиур үүсгэдэггүй нян. **Тээгчид** нь энэ нянгараа өвчлөхгүй байх нь элбэг. *Алтлаг Стафилококк* нь заримдаа шархны халдварт өвчлөл, хатиг, тууралт гэх мэт **халдвар** үүсгэдэг тул эмчлэх ёстой болно.

MRSA эрсдэлтэй юу?

MRSA өөр халдвар үүсгэхгүй ч эмчлэхэд хэцүү байх талтай. Эрсдэл нь эмчлэгдтэлээ удах эсвэл гаж нөлөө ихтэй антибиотик хэрэглэх ёстойд оршиж байна. Өөр нэг эрсдэл бол энэ тэсвэртэй нян эмнэлэг буюу халдварт эсэргүүцэл муутай олон өвчтөний дунд болон антибиотик их хэрэглэдэг орчинд тархах явдал юм. Энэ эрсдэл Шведтэй харьцуулахад MRSA илүү элбэг байдаг гадаадын эмнэлэгт ялангуяа их.

MRSA хэрхэн халдварлах вэ?

MRSA-гаар өвчлөөгүй ба зөвхөн тээгч хүн ерөнхийдөө бусдад халдваргүй. Гэвч түүний арьсанд халдварт өвчлөл, удаан эдгэхгүй байгаа эсвэл шингэн шүүрсэн шарх болон экзем бий бол түүний бусдад халдаах эрсдэл өснө. Ийм нөхцөлийг халдвар тараах **эрсдлийн хүчин зүйл** гэнэ. Эрсдлийн хүчин зүйлд мөн зарим арьсны архаг өвчин болон арьс, салслагаар дамжин өнгөрдөг биенд оруулсан нүх, гуурс юм. Эрсдлийн хүчин зүйлээр олон нян дамжина. Халдвар тараах эрсдлийн хүчин зүйл өөрт нь бүрдсэн MRSA тээгч гэр бүл дэх эсвэл цэцэрлэг дээрх хүмүүст, амьтантай харьцах үед, спорт, биеийн тамирын биеийн хавьтлын үеэр болон дасгал бэлтгэл хийх байр, гут-д халдвар тарааж болно. MRSA гараар бусдад халдах ба, бариул, дасгалын дэвсгэр гэх мэт эргэн тойрны эд зүйлд наалдаж үлдэнэ. Халдвар тархалт мөн эмнэлэг, настан асрах байр болон бусад эмнэлгийн орчинд тохиолдоно.

MRSA-гаас салж болох уу?

MRSA хэсэг хугацааны дараа шинжилгээнд илрэхгүй болох нь элбэг. Хэзээ гэдэг нь хүн бүр дээр өөр байх ба, хэдэн сараас хэдэн жил болтол удаж болох тул урьдчилж хэлэхэд хэцүү. MRSA-г хариуцсан эмч халдвар хамгааллын эмчийн хамт MRSA-гийн хяналт болон мөрдөх дүрмийг өвчтөний хувьд хэзээ шаардлагагүй болох дүгнэлтийг гаргана. Хэрэв дор хаяж нэг жилийн хугацаанд гурав дараалсан шинжилгээнд MRSA илрэхгүй бол ийм дүгнэлт хийж болно.

Та юунд анхаарах хэрэгтэй вэ

- Гарын ариун цэвэр сахих нь халдвараас сэргийлэх хамгийн чухал арга хэмжээ мөн. Шингэн савангаар гараа угаах хэрэгтэй.
- Та зөвхөн MRSA-тээгч, өөрөөр хэлбэл халдвар тараах эрсдлийн хүчин зүйлгүй бол, бусадтай хэвийн байдлаар харьцаж болно.
- Танд халдвар тараах эрсдлийн хүчин зүйл бүрдсэн бол таны бусдад халдвар тараах эрсдэл өснө. Энэ нөхцөлд та ариун цэвэр сайн сахих нь чухал. Гараа угаахад сайн анхаар. Өөрийн алчуур болон хувийн ариун цэврийн хэрэгсэлтэй бай. Усан сан эсвэл бассейнд орохын оронд шүршүүрт ор. Шархандаа боолт нааж, шингэн шүүрсэн бол соль. Танд катетер гуурс суулгасан бол хувцасныхаа доор байлга. Шарх эсвэл катетер гуурстайгаа харьцсан бол гараа угаа.
- Арьсанд тань халдварт өвчлөл, удаан эдгэхгүй байгаа эсвэл шингэн шүүрсэн шарх эсвэл экзем бол биеийн хавьтал их болдог спорт, биеийн тамираар хичээллэхгүй байж, олон хүн хуваалцдаг дасгал бэлтгэл хийх байр болон gym-д орохгүй бай.
- Танд халдвар тараах эрсдлийн хүчин зүйл бүрдсэн бол амьтантай хавьтахын өмнө гарын ариун цэвэр хангах нь чухал, учир нь амьтад мөн MRSA тээж болно.

Тусгай санал зөвлөмж

- Эмнэлэг болон асаргааны салбарын хөдөлмөр эрхлэгч ба оюутнууд халдвар тараах эрсдлийн хүчин зүйлтэй бол эмчилгээ асаргааны ажлаа хийж болохгүй. Онц мэдрэг өвчтөнтэй тасагт ажиллах хөдөлмөр эрхлэгч шинжилгээ өгч MRSA илрээгүй гэсэн хариутай нөхцөлд л ажлаа хийх шаардлага тавигддаг.
- Хүүхдүүд ер нь цэцэрлэгтээ явж, бүх үйл ажиллагаанд оролцож болно. Тэд харин халдварт өвчлөл, удаан эдгэхгүй байгаа эсвэл шингэн шүүрсэн шарх эсвэл экземтэй бол цэцэрлэгтээ явж болохгүй.
- Амьтантай ажиллах мэргэжлийн хүн амьтанд нянг халдаахгүй байх нь чухал. Тэд үүн дээр халдвар хамгааллын эмч болон аймгийн малын эмчээс зөвлөгөө авах хэрэгтэй.

Танд Халдвар хамгааллын хуулийн дагуу мөрдөх ёстой дүрэм бий

- Та эмнэлэгт эргэн ирж үзүүлж, эмчийн өгөх шаардлагатай гэсэн шинжилгээг өгөх ёстой.
- Та халдварын мөрдөлтөнд хамтарч ажиллах ёстой. Ингэхийн тулд та эмнэлгийн ажил эрхлэгчид холбогдох мэдээллийг өгөх ёстой ба, тэд таныг хэзээ, хаана, хэрхэн халдвар авсан болох, мөн та бусдад халдвар тараасан байх магадлалтай эсэхийг дүгнэнэ.
- Та эмнэлгийн тусламж, шүдний эмчилгээ болон хөлийн эмчилгээ авах үедээ өөрийгөө MRSA-халдвартай гэж хэлэх ёстой. Мөн гэртээ юмуу асаргааны газар хувийн асаргаа үйлчилгээ авч байгаа бол бас энэ тухайгаа мэдэгдэх ёстой. Та дэлгүүрийн худалдаа хийх, цэвэрлэгээ хийх, эмээ хуваарилах, салхинд алхах гэх мэт зүйлд ойр зуурын туслалцаа авдаг бол MRSA-халдвартай тухайгаа ихэнхдээ мэдэгдэх шаардлагагүй.
- Танд халдвар тараах эрсдлийн хүчин зүйл бүрдсэн бол чих цоолох болон шивээс, массаж, эмчилгээний бус хөлний эмчилгээ үйлчилгээ гэх мэт арьс ба салслагийн үйлчилгээ авах үедээ MRSA-халдвартай тухайгаа хэлэх ёстой. Та эрсдлийн хүчин зүйлгүй болсны дараа ийм эмчилгээ үйлчилгээ авбал сайн.

MRSA нь Халдвар хамгааллын хуулийн дагуу ноцтой өвчинд тооцогддог. Тиймд та эмчийн өгсөн мөрдөх дүрмийг дагах нь чухал. Та өөрийн аймгийн халдвар хамгааллын эмчээр өөрт өгсөн мөрдөх дүрмийг өөрчлүүлэхийг хүсч болно.